

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Биелэлт	Хувь
<i>Зорилт-1: Хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр</i>					
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх.	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх.	<p>Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн 233,896 дагагч бүхий албан ёсны пэйж хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны пэйж хуудаснаас мэдээ, мэдээллийг эх сурвалжийг нь заан хуулбарлан авч, иргэд, олон нийтэд цахимаар хүргэх ажлыг зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утга агуулга бүхий постер, мэдээ, мэдээллийг тухай бүр нийтэлж, 20 гаруй мэдээллийг өөрийн пэйж хуудсанд байршуулан, Авлигатай тэмцэх газраас хийсэн авлигын эсрэг шторкод алба хаагчдаар уриалга хэлүүлж, дэмжлэг үзүүлэв.</p> <p>Мөрдөн байцаах албаны төвийн хэлтсийн 131, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах тасгийн 511 алба хаагчдыг Авлигатай тэмцэх газрын “АТГ-Олон нийтийн төв”, АТГын дэргэдэх олон Олон нийтийн зөвлөл” нэртэй фэйсбүүкийн пэйж хуудсанд нэгдүүлэх ажлыг зохион байгуулж, уг пэйж хуудсанд тавигдсан 27 видео мэдээ, “Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн хэрэгцээ, шаардлага сэдэвт хэлэлцүүлэг, 18 шторк, 5 инфографик, 31 нийтлэл, 4 теле зохиомж, 33 постер, 78 дэмжих мэдээ мэдээлэл, нийт 197 мэдээллийг тус албаны “Мөрдөн байцаах алба”, “МБА-Албан хэрэгцээнд” олон нийтийн сүлжээ /facebook/ хуудас, www.mba.police.gov сайт, иргэд угтах танхимын “Ухаалаг дэлгэц” зэрэгт байршуулсныг 36.237 хэрэглэгч хуваалцаж, 11.076 лайк дарж, 5714 эерэг сэтгэгдэл бичсэн байна. Мөн авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, авлигыг мэдээлэх талаар иргэдэд сурталчлан таниулах зорилгоор мэдүүлэг авах 6 өрөө, иргэдийн хүлээх танхимд “Авлигыг мэдээл 110 дугаарын утас” “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”</p>	100

				<p>сурталчилсан тараах материал 58 ширхэгийг байршуулж, ухаалаг дэлгэцэд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг хууль”, “Ашиг сонирхолын харандаа”, “Авлигыг үл тэвчих үзэл суртлыг ухууль” “Шударга нийгмийн төлөө энэ өдөр бүгд дор бүрнээ #АвлигынЭсрэг #НэгҮйлдэл хийе” уриалга бүхий 9 минутын видеог байршуулсан.</p> <p>Эрүүгийн цагдаагийн албанаас “Бид авлигыг зогсоож чадна”, “Авлига бүү өг, бүү ав” сэдэвт зурагт хуудсыг пэйж хуудсанд 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байршуулснаар нийт 5492 хүнд хүрч, 224 хүнд таалагдаж, 77 хүн сэтгэгдэл үлдээж, 106 хүн бусадтай хуваалцсан байна.</p> <p>Мөн 12,803 дагагчтай Эрүүгийн цагдаагийн албаны фэйсбүүк пэйж хуудсанд “Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?” гэх сэдэвт 5 минут 12 секундын бичлэг байршуулсныг 4,991 хүн үзэж сонирхон, 322 хүн нийтлэлтэй харьцсан байна. Мөн иргэд олон нийтэд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд 2 минут 16 секундийн видео шторкыг бэлтгэн байршуулсаныг 3,867 иргэн үзэж, танилцсан байна.</p> <p>Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас АТГ-ын “Нийтийн албан тушаалтан ТА”, “Шударга нийгмийн төлөө хамтдаа”, “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “Мэдүүлэг гаргагч таны үүрэг”, “Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээллийг 110 тусгай дугаарын утсаар хүлээн авч байгаа талаарх” зурагт хуудсыг ЦЕГ-ын III байр, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн “Мэдээлэл, ил тод байдал” самбарт, “Албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалт”, “Авлига, ашиг, сонирхлын зөрчлийн талаарх ойлголт”, “Мэдүүлэг гаргагчийн үүрэг” зэрэг зурагт хуудсыг алба хаагчдын өрөөнд тус тус байршуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас YouTube-д байршуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн видео шторк Тухайлбал: “Авлигын цаана”, “Саарал хүмүүс” “Зөв шүүлт, шудрага тоглолт”, “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аян, Өрөг хэлэлцүүлэг Авлигын гэмт хэргийн ялын бодлого богино хэмжээний видео бичлэгүүдийг болон “Авлигатай Тэмцэх Газар”, АТГ-Олон Нийтийн Төв” фэйсбүүк цахим хуудсанд байршуулсан Стори мэдээ, www.mplus.mn сайтад байршуулсан авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий мэдээлэл агуулсан “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” подкастуудыг албаны https://information.police.gov.mn/, www.eincenter.mn цахим сайт, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны алба</p>
--	--	--	--	--

				<p>хаагчдын фэйсбүүк группд байршуулж мэдээ, мэдээлэл өгч, сурталчлав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн уриалгын дагуу “Авлигыг мэдээлэх утас-110”, “Шударга ёс, хөгжил дэвшилд” зурагт хуудсыг видео хэлбэртэйгээр цагдаагийн байгууллагын https://police.gov.mn болон МДШШУА-ны https://information.police.gov.mn/ цахим сайтуудын “Видео мэдээ” буланд байршуулав.</p> <p>Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвийн цахим хуудсанд 2022 онд нийт 519 алба хаагчийг нэгдүүлж, тус албаны “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба”, “НХЖХОНАБХА-ны СУРГАЛТ” нэртэй фэйсбүүк пейж хуудас, мөн албаны цахим самбарт Авлигатай тэмцэх газар болон мөн газрын Олон нийтийн төвөөс боловсруулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх”, “Хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх вэ?” зэрэг сэдэвт нийт 33 төрлийн сургалтын материал, шторкыг байршуулан 32584 алба хаагч, иргэдэд сурталчилж ажилласан.</p> <p>Тус албаны мэдээллийн болон хүндэтгэлийн самбарыг цахим хэлбэрт шилжүүлж, гадаад, дотоодын олны танил 15 эрхэмийн авлигын эсрэг хэлсэн титэм үг болон зураг хуудсыг байршуулж, иргэд олон нийт, алба хаагчдад өдөр бүр түгээж, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 150 гарын авлага, хэвлэмэл хуудсыг бүтцийн 9 нэгжид тарааж, судлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Нийслэлийн цагдаагийн удирдах газраас уг заалтын хүрээнд: “Эрүү шүүлтийг таслан зогсооё, Авлигын талаар 110 дугаарт мэдээллэх” гэсэн мэдээллийг харьяа нэгжүүдийн хэмжээнд нийт 200 хаалганы гадна талд байршуулсан. Мөн энэ оны 3 дугаар улиралд алба хаагчдыг авлигаас ангид байлгах зорилгоор Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигыг мэдээлэх утас 110 буюу “Өгөхгүй бай, нэхвэл илчил”, “Шударга ёс, хөгжил дэвшилд”, “ТАТ” бичиглэл бүхий хаалганы 100 ширхэг наалтыг алба хаагчдын өрөө тасалгаа, цагдаагийн газар, хэлтсийн байранд байршуулан нийтэд сурталчилж ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулсан “Зөв зөвд, шударга зөв” аяныг алба хаагчдад сурталчилж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пейж фэйсбүүк хуудаст QR кодыг уншуулан нэгдэхийг алба хаагчдад сурталчлан Мөрдөн шалгах газрын 60, Нийтийн хэв журам хамгаалах газрын Хэв журмын хэлтсийн 20, Шөнийн эргүүлийн хэлтсийн 55, Эрүүлжүүлэх, саатуулах төвийн 52, Захиргааны удирдлагын газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн 10, Төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 15, Санхүү аж ахуйн хэлтсийн 15, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх</p>
--	--	--	--	---

				<p>хэлтсийн 34, Шуурхай удирдлагын хэлтсийн 25, Дотоод аюулгүй байдлын 26 алба хаагч, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын 388 буюу нийт 700 алба хаагчдыг тус тус нэгдүүлсэн.</p> <p>Аймгуудын цагдаагийн газраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээ, мэдээллийг татан авч байгууллагын цахим хаяг, аймгийн телевиз /Архангай 2, Баян-Өлгий-2, Орхон-2, Өмнөговь-3, Увс-2/-үүдээр сурталчилж, нутгийн захиргааны ордны гадна болон үйлчилгээний төвүүдийн гадна байрлах лед дэлгэцээр, алба хаагчдын өрөө, тасалгааны хаалга, байгууллагын орох, гарах гарцын хаалга дээр “Авлигагүй орчин” гэсэн бичиглэлийг нааж алба хаагч, ажилтан, иргэд, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна.</p> <p>Авлигын эсрэг олон улсын өдрийг угтаж Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээж авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан логог байгууллага бүр цахим болон фейсбүүк хаягт /нүүр хуудаст/ байршуулж сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p>	
		<p>1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.</p>	<p>-Дэмжиж хамтран ажилласан байх. -Алба, нэгж, орон нутагт, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” аяныг байгууллагын алба хаагчдад сурталчилж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пейж фейсбүүк хуудаст QR кодыг уншуулан нэгдэх, дагах ажилд нийт 60 нэгжийн 7850 алба хаагч оролцож, нэгжүүдээс дүн, нотломжийг нэгтгэн авч, тооцсон.</p> <p>Тээврийн цагдаагийн албанаас “Хичээл зүтгэл” аяныг зохион байгуулж 7 хоног бүрийн мягмар, баасан гаригуудад алба хаагч нарт Авлигаас урьдчилан сэргийлэх, зөв хүн байх, архины хор хөнөөл зэрэг сэдвүүдээр тогтмол хичээл сургалтыг зохион байгуулж гаднаас багш нарыг урьж сургалт соён гэгээрүүлэх чиглэлээр ажил арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>Мөрдөн байцаах албаны алба хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах чиглэлээр “Авлигад үгүй гэж хэлье” нөлөөллийн арга хэмжээг энэ оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 21 хоногийн хугацаанд зохион байгуулах 8 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, албаны 9 хэлтсийг гурван багт хуваан, хариуцсан 7 хоногтоо энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах хуваарийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар төлөвлөгөөний дагуу 4 удаагийн сургалт, 3 удаагийн соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан</p> <p>Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас Авлигатай тэмцэх газраас улс даяар өрнүүлж буй</p>	80

				<p>“Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” уриалгыг дэмжиж, сургалтын үйл ажиллагааг алба хаагч, олон нийтэд сурталчлах чиглэлээр видео танилцуулга бэлтгэн “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба”, байгууллагын сургалтын хаалттай “НХЖХОНАБХА-ны СУРГАЛТ” цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс энэ оны 05 дугаар сарын 25-ны өдөр “Зөв шүүлт” аяны удирдамж боловсруулан төвийн даргаар батлуулан 14 хоногийн хугацаанд аяныг зохион байгуулж, иргэдэд мэдээлэх сурталчлах хууль тогтоомж, заавар, зөвлөмж, авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогчдын 2019, 2020, 2021 оны илтгэлийн эмхэтгэл, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан зурагт хуудас, наалт, лого, шторк болон цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын танхим, жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа авто сургуулиудын тээврийн хэрэгслүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх “Зөв шүүлт-Шударга тоглолт” зурагт хуудас, боршур, ном, сэтгүүл, зөвлөмжийг байршуулж, шалгуулагч нарт гарын авлага, боршур тарааж ажилласан.</p> <p>Архангай аймгийн цагдаагийн газраас энэ оны 05 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд иргэд олон нийтэд хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор мэдээ, мэдээллийг өгч сурталчилсан.</p> <p>Өвөрхангай аймгийн цагдаагийн газраас аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” сэдэвт 45 хоногийн аян зохион байгуулж, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх зорилготой “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк цахим хуудсанд алба хаагчдыг бүрэн нэгдүүлсэн.</p> <p>Орхон аймгийн цагдаагийн газраас 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газартай хамтран “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгийн үеэр Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар, хөлтэй баннер байрлуулан иргэд олон нийтэд сурталчлан ажилласан, арга хэмжээг нийт 600-800 иргэн сонирхож, 150-200 иргэд хууль эрх зүйн болон бусад төрлийн зөвлөгөө мэдэгдэл өгсөн байна.</p>	
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн	-Мэдээллийг тогтмол	Авлигатай тэмцэх газрын “Авлигыг мэдээлэх утас-110”, “Шударга ёс, хөгжил дэвшилд” зурагт хуудсыг видео хэлбэртэйгээр Цагдаагийн	100

		<p>сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.</p>	<p>шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх.</p> <ul style="list-style-type: none"> - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх. - Иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар мониторинг, судалгаа хийсэн байх. 	<p>ерөнхий газрын https://police.gov.mn болон МДШУА-ны https://information.police.gov.mn цахим сайтуудын “Видео мэдээ” буланд байршуулсан.</p> <p>Албад болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд өөрсдийн цахим хаяг болон фейсбүүк хаягт “Авлигыг мэдээлэх утас-110” логог нүүр хуудсандаа байршуулж, байрны “Иргэд хүлээн авах танхим”-д “Шударга ёс, хөгжил дэвшилд” авлигын эсрэг мэдээллийн самбарыг байршуулж, мэдээллийг боломжит хугацаанд буюу сар, улирал тутамд шинэчлэн ажилласан.</p> <p>Хэвлэл мэдээллийн төв, Сургалтын нэгдсэн төвүүдээс Шударга шүүлт аяны хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэх сурталчлах, хууль тогтоомж, заавар, зөвлөмж, авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогчдын 2019, 2020, 2021 оны илтгэлийн эмхэтгэл, мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага, авлигын нөхцөл байдлын мэдээлэл, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан зурагт хуудас, наалт, лого, шторк, бал болон цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг хүлээн авч байгууллагын иргэд хүлээн авах болон мэдээллийн самбарт байрлуулсан.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс үйлчилгээ авахаар ирсэн иргэдээс жолоочийн үнэмлэх олголт, дүрмийн шалгалт, галт зэвсгийн зөвшөөрөл, шилжилт хөдөлгөөн, гэрээт харуул хамгаалалт, тусгай дуут болон гэрэл дохионы зөвшөөрөл олголтод ашиг сонирхлын зөрчил үүсэж байгаа эсэх талаарх санал асуулгыг 06 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Санал асуулгад 134 иргэн оролцсон бөгөөд судалгааны дүнг нэгтгэн төвийн даргад танилцуулан иргэдээс гаргасан, саналыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Санал асуулгын дүнгийн талаар:</p> <p>Тус төвийн үйл ажиллагаа иргэдэд хүрч чадаж байна уу? Нийт иргэдийн 113 буюу 84.3% нь “Тийм”, 21 буюу 15.7 буюу “Үгүй”, эсвэл хариулаагүй орхисон.</p> <p>Та үйлчилгээ авахад хүндрэл, хүнд суртал гаргасан уу? Иргэдийн 93 буюу 69.4 % нь “Үгүй”, 34 буюу 25.3 % нь “Заримдаа”, 7 буюу 5.3 % нь “Тийм” буюу хариулаагүй орхисон.</p> <p>Та тус төвд авлига, ашиг сонирхлын зөрчил хэр байна? Иргэдийн 23 буюу 17.1 % нь “Зөрчил үүсэх эрсдэлтэй”, 76 буюу 56.7 % нь “Мэдэхгүй”, 11 буюу 8.2 % нь “Эрсдэлгүй”, 24 буюу 17.9% нь хариулаагүй орхисон байна.</p> <p>Тус төвийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд ил тод, нээлттэй болгох талаар таны бодол зэрэг санал асуулга авч</p>
--	--	--	--	---

				ажилласан. Санал өгсөн иргэдийн 109 буюу 81.3% нь үйлчилгээг цахимаар хүргэх талаар санал гаргасан бол үйлчилгээ үзүүлж буй байр, байршлын талаар анхаарах, үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд сурталчлах, алба хаагчдыг нэг цэгийн бүх үйлчилгээний төвүүдэд тараан ажиллуулах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын хуваарийг олон нийтийн мэдээллийн сайтад тавих, түүнийг боловсронгуй болгох талаар анхаарах зэрэг саналыг асуумжид дурдсан байна.	
Зорилт-2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах чиглэлээр					
2	Албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах.	2.1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулах.	-Сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо.	Авлигатай тэмцэх газраас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан давтан сургалтад 35, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаа” сэдэвт сургагч багш нарыг чадавхжуулах 2 өдрийн давтан сургалтад 52 алба хаагч тус тус хамрагдсан.	80
		2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргэх, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнах.	- Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх. - Хамрагдсан алба хаагчдын тоо.	Хэвлэл мэдээллийн төвөөс энэ оны 3 дугаар сарын 04-ний өдөр Авлигын эсрэг хуулийг сурталчлах зорилгоор “Авилгад үгүй гэж хэлье” видео шторкыг бэлтгэж, олон нийтэд түгээсэн нь 9824 хүнд хүрээд байна. Транспэрэнси интернэшнл байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах зорилго бүхий ажлын хэсгийн авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө”-ний цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хамааралтай заалтын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Дэд даргын ахалсан ажлын хэсгээс гарсан шийдвэрийн дагуу алба хаагчдын авлигын хор хөнөөл эрсдэлийн талаар болон хууль тогтоомж, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, баталгаажуулах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас Хуулийн хэлтэстэй хамтран улирал тутамд цахим шалгалт зохион байгуулсан. “Авилгад үгүй гэж хэлье” аяны хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор уршгийг ухуулан таниулах чиглэлээр 46 сургагч багш 96 удаагийн 266 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 15710 алба хаагч хамрууллаа. Сургагч багш нараас зохион байгуулсан сургалт, нөлөөллийн аяны хүрээнд алба хаагчдын авлигын хор хөнөөл эрсдэлийн талаар болон хууль тогтоомж, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой цахим 4 дэх шалгалтын идэвх, оролцоо эхний удаагийнхаас 29.2 хувиар, үнэлгээний чанар 14,2 хувиар, амжилт 38,8 хувиар тус тус	96

				<p>өссөн үзүүлэлттэй байх тул цаашид улирал тутамд зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хуулийн хэлтсээс Мөрдөн байцаах албатай хамтран цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглэх чадавхыг сайжруулах, харилцааны эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор “Хүний эрх ба цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг” сэдэвт практик сургалтыг зохион байгуулж, 30 анги, байгууллагын 3693 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнтэй харилцан мэдээлэл солилцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор нээсэн “Алба хаагчдын чөлөөт индэр” фэйсбүүк хязгаарлалттай группт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “Хөрөнгө орлогын мэдүүлэг, түүний тухай ойлголт, алба хаагчдаас гаргадаг нийтлэг алдаа дутагдал, анхаарах асуудал” сэдвээр шууд дамжуулалт /live/ хийснийг давхардсан тоогоор 6445 алба хаагч үзэж, 596 алба хаагчид таалагдаж, алба хаагчдаас коммент хэсгээр ирүүлсэн 507 санал хүсэлтэд хариулт өгсөн.</p> <p>“Алба хаагчдын чөлөөт индэр” хязгаарлалттай фэйсбүүк группт Авлигатай тэмцэх газартай хамтран “Алба хаагчдаас гаргаж байгаа нийтлэг алдаа дутагдал, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагч давхар ажил эрхлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт” сэдвээр энэ оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 14:00 цагаас 15:00 цагийн хооронд шууд дамжуулалтад /live/ хийж, давхардсан тоогоор 2298 алба хаагч үзэж, 235 хаагчид таалагдаж, алба хаагчдаас коммент хэсгээр ирүүлсэн 302 санал, сэтгэгдлээс 12 асуултад АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, ахлах комиссар Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан ахлах комиссар Ц.Баасандэлгэр, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ундармаа нар хариулт мэдээлэл өгсөн.</p>	
<i>Зорилт-3: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр</i>					
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах. Монгол Улсад Гэмт	-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Нямгэрэлээс 2022 оны 2/44 албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийн Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад хамааралтай 23 заалтыг	90

	<p>хугацаанд нь мэдэгдэх.</p>	<p>хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Л.Нямгэрэлээс 2022 оны 2/44 албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах./</p>		<p>эзэнжүүлэн батлуулж, Дэд даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 3/151 дугаартай албан бичгээр харьяа нэгжүүдэд хэрэгжилтийг хангуулахаар хүргүүлэн, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцож, 90 хувьтайгаар дүгнэлээ.</p> <p>Тухайлбал: Зөвлөмжийн 2.7-д заасан Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжээс эрхэлж буй аливаа үйлчилгээ үйл ажиллагаанд хуульд заагаагүй зөвшөөрөл олгодог явдлыг таслан зогсоох, төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тогтолцоог халах заалтыг Бүртгэл, хяналтын төвөөс хариуцан, Цагдаагийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгож байгаа зөвшөөрлийн системийг боловсронгуй болгох зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал “E-Mongolia” цахим системээр дамжуулан “Галт зэвсгийн гэрчилгээ олгох”, “Монгол улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх, худалдан борлуулах төвөөс худалдан авах зөвшөөрөл олгох”, “Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх”, “Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөл, бүртгэл”-ийн зөвшөөрлийг энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож эхлээд байна.</p> <p>“E-Mongolia” цахим системээр дамжуулан зөвшөөрөл хүссэн иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын бүрдүүлэх материалын жагсаалтаас иргэний үнэмлэхний хуулбар, оршин суугаа газрын тодорхойлолт, ял шийтгэлтэй эсэх лавлагаа, галт зэвсгийн сургалтад суусан гэрчилгээ, улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг бичиг баримтуудыг хасч, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
		<p>3.2. Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу арга хэмжээ зохион байгуулж, хуулийн хугацаанд хариу хүргүүлэх.</p>		<p>Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн 13 мэдэгдлийг хүлээн авч бүртгэн, хариуцсан нэгжүүдэд албан бичгээр хүргүүлж, мэдэгдлийн мөрөөр алба хаагчдад мэдээлэл хийх, алба хаагчдыг авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган сургалт зохион байгуулж, хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлж, хариу ирүүлэх тухай чиглэл хүргэсэн.</p> <p>Авлигатай тэмцэх газарт мэдэгдлийн мөрөөр Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа А.Энхбат, Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа У.Мөнхсансар нарыг албан тушаал бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан тухай албан бичиг хүргүүлсэн.</p> <p>Мөрдөн байцаах албанаас 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн №54 дугаартай “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг хүлээн авч, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12/1-2311 дугаар албан бичгээр харьяа нэгжүүдэд хүргүүлэн, харьяа 54 нэгжийн алба хаагч нарт танилцуулж,</p>	<p>91</p>

				<p>мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан тушаалтнуудад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйл /Өмгөөлөгч оролцуулах/, 25.3 дугаар зүйл /Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах/, мөн хуулийн 18 дугаар бүлэг/Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөн хуулийн 16.1 дүгээр зүйл /Нотлох баримт/, 16.14 дүгээр зүйл /Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх/д заасан тодорхой төрлийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хууль тогтоомж, эрх зүйн актыг судалж үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй мөрдөж ажиллах талаар сургалтыг зохион байгуулсан.</p> <p><i>МДШШУА:</i> АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Л.Батгэрэлийн энэ оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 29 дугаартай “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийн дагуу тус албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Шуурхай удирдлагын хэлтэс /103/-ийн дарга, цагдаагийн хошууч Т.Бат-Идэр гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байх тул Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс албаны шалгалт явуулж, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.13 дахь заалтыг зөрчсөн болох нь тогтоогдсон тул Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Б/443 дугаар тушаалаар Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.3 дахь хэсэгт зааснаар “албаны тушаал бууруулах” сахилгын шийтгэл оногдуулж, “цагдаагийн хошууч” цолыг хураан “цагдаагийн ахлах ахлагч” цол олгож, мөн төвийн Захиргааны удирдлагын хэлтэст жижүүрийн цагдаа албан тушаалд томилж, зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх хариуг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022.04.19-ний өдрийн 8а/821 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>	
<i>Зорилт-4 : Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр</i>					
4	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.	4.1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжилтийг хангуулах.	-Цагдаагийн байгууллагын нэгжүүдэд авлигын эсрэг үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг хүргүүлсэн байх.	Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 зорилт, 48 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, харьяа нэгжүүдэд хэрэгжилтийг хангуулахаар Дэд даргын 3/151 дугаартай албан бичгээр нэгжүүдэд хүргүүлсэн.	100

		<p>4.2. Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгтгэн дүгнэж, нотломжийн хамт “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим санд тайлагнах.</p>	<p>-Хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд АТГ-ын “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим санд тайлагнасан байх.</p>	<p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг нэгдсэн загвар хүснэгтийн дагуу гаргаж, Авлигын эсрэг үндэсний сүлжээний khutulbur.iaac.mn цахим сайтад 72.9 хувьтайгаар байршуулж, Авлигатай тэмцэх газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 6/5725 дугаартай албан бичгээр хүргэж, дүгнүүлсэн. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг 98.1 хувь болгон ахиулсан.</p>	98
<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.</p>		<p>4.3. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга, уриаг дэмжин, аян зохион байгуулахад оролцох.</p>	<p>-Иргэн, хуулийн этгээдэд Авлигын эсрэг хууль тогтоомж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сурталчилсан байх.</p>	<p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагаас хийсэн хэрэглэгчийн үнэлгээний судалгаа, өмнөх жилийн сургалтын чанар, үр дүн, нэгжүүдээс ирүүлсэн санал, сургалтын хэрэгцээ, сахилга, ёс зүйн зөрчлийн судалгаа зэрэгт үндэслэн албаны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, түүнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах заалтыг тусгаж батлуулсан.</p> <p>Дэлхийн банкны “Стар нэгж”-ээс санаачлан Цагдаа, прокурорын байгууллага болон Авлигатай тэмцэх газрын алба хаагч нарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд “Санхүүгийн мөрдлөг” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Эрүүгийн цагдаагийн албанаас 7 алба хаагчийг, АНУ-ын Элчин Сайдын яамны Нууц албанаас энэ оны 03 дугаар сарын 28,29-ний өдрүүдэд Монгол Улсын Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллагын алба хаагчдад зориулан зохион байгуулсан “Цахим нотлох баримт, криптовалют” сэдэвт мэргэшүүлэх сургалтад төв, орон нутгийн 20 эрүүгийн мөрдөгчийг тус тус хамруулсан.</p> <p>Мөн Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын санхүүжилтээр Азийн сангаас хэрэгжүүлж байгаа “Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай тэмцэх чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Уул уурхайн салбар дахь зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт семинарыг 2022 оны 04 дүгээр сарын 05-08-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг семинар нь хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг түүнтэй холбогдсон авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөгч, прокурор, шүүгчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр</p>	90

			<p>харилцан туршлага солилцсон бөгөөд семинарт Экологийн цагдаагийн алба, Эрүүгийн цагдаагийн албаны 46 алба хаагчийг хамрууллаа.</p> <p>Архангай, Орхон, Өвөрхангай аймгийн цагдаагийн газраас аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” сэдэвт 45 хоногийн аяныг 4,5 дугаар сард зохион байгуулж, аяны хүрээнд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-өөр иргэд, олон нийтэд авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарын авлага, брошур, зурагт хуудсыг тарааж, шаардлагатай хууль, эрх зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан байна.</p>	
	4.4. Цагдаагийн байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын 2023 оны төсөвт тусгуулах санал хүргүүлэх.		<p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чиглэгдсэн ажлыг Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгаж оруулахаар төлөвлөсөн.</p>	100
	4.5. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.		<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” заалтын хэрэгжилтийг хангуулахаар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягтыг 2022 онд албаны шалгалт явуулсан, гэрээ хэлцэл байгуулсан, худалдан авах ажиллагаанд оролцсон алба хаагчдаас гаргуулан авч, санд бүртгэх, цаашид үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллахыг Эрх бүхий албан тушаалтнуудад чиглэл хүргүүлсний дүнд Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим санд 2020 онд 51, 2021 онд 151 бүртгэгдэж байсан мэдэгдлийн тоо энэ оны жилийн эцсийн байдлаар 370 болж өссөн үр дүнтэй байна.</p> <p>Дээрхи алба хаагчдаас 6 нь ашиг сонирхлын зөрчилтэй талаар мэдэгдэж, зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэж, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлсэн байна.</p> <p>Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас Монголбанк болон Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтарсан хамгаалалтын гэрээ, хэлэлцээр болон худалдан авах</p>	100

			<p>ажиллагаатай холбоотой гэрээнүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх талаар тусган, гэрээний орлогыг сар бүр төсвийн дансанд төвлөрүүлэн, шилэн дансны цахим хуудасны “төсөв гүйцэтгэл” цэсэнд байршуулсан.</p> <p>Экологийн цагдаагийн албанаас төрийн болон орон нутгийн өмчөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын даргын энэ оны А/55 дугаар захирамжаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний аяны хүрээнд 100.0 сая, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын энэ оны 62 дугаар захирамжаар “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус хүлээн авч, зарцуулах эрхийг нээлгүүлэн, холбогдох эрх зүйн акт, журам, төлөвлөгөөний дагуу 16 аж ахуйн нэгж байгууллагуудтай худалдах, худалдан авах гэрээг хариуцсан алба хаагчдаас байгуулахад нь УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягыг танилцуулж, бөглүүлсэн.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”, тээврийн хэрэгслийн жолоодох эрх сэргээх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, Төрийн бус байгууллагуудтай 2022 онд байгуулсан сургалтын гэрээний авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтуудын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зурагт хуудас, брошур, ном, сэтгүүл, зөвлөмжийг сургалтын анги, танхимд байрлуулж, иргэд, олон нийтэд сурталчилсан. - Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны ахлах комиссар С.Галбадрах энэ оны 06 дугаар сарын 06-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 13 ТББ-ын удирдлага, багш нарын 28 хүнийг хамруулан зохион байгуулсан. <p>Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын сэдэв, агуулгаас гадна авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд анхааруулга, сэрэмжлүүлгийг сургалтын тодорхой цагт багтаан, иргэд, суралцагчдад сурталчлан хүргэлээ.</p>
--	--	--	---

		4.6. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачлага өрнүүлэх.		<p>Дэд даргаас энэ оны 2 дугаар сард алба хаагчдаас үйлдэж байгаа сахилга, ёс зүйн зөрчил /хэлбэр/-өөр 5 хүртэлх минутын богино хэмжээний киног бэлтгэж ирүүлэх, кинонуудыг дүгнэж, 20 хүртэлх минутын сургалтын кино болгох, чиглэлийг өгсний дагуу:</p> <p>Хахууль, шан харамж авсан, өгсөн, бусдад давуу байдал бий болгосон, бусдын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон бүлэгт нийт 5 бүтээл өрсөлдсөнөөс Ховд аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн 4 минут 24 секундний богино хэмжээний киног сонгон шалгаруулж, сургалтын материал бэлтгэж, алба хаагчдад хүргэсэн.</p> <p>Цагдаагийн байгууллагаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаарх мэдээллийг иргэдээс 24 цагаар хүлээн авах 126 тусгай дугаарын утсыг 2014 оноос эхлэн ажиллуулсан боловч иргэдээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой бүх төрлийн гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг ирүүлж байна.</p> <p>Иргэд, байгууллагаас энэ онд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой 652 гомдол мэдээлэл ирүүлсэнээс 607 гомдол мэдээллийг харьяа газар хэлтсүүд шалгаж шийдвэрлэн, буруутай нь тогтоогдсон 27 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулан, 45 гомдол, мэдээллийг ажиллагаанд шалгаж байна.</p> <p>Харьяа албадуудаас алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэх явцад хууль сахиулах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлого гарсан тохиолдолд авлигаас татгалзах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа /код-139/ журам”-ын 139.61в маягтын дагуу тэмдэглэл хөтөлж, мэдээлсэн тохиолдолд тухайн анги, байгууллагын дарга тухайн алба хаагчийг урамшуулж байх талаар алба хаагчдад танилцуулан мэдээлэл өгч, баталгаа гаргуулсан байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” өдөрлөгийг энэ оны 5 дугаар сарын 20-ны өдөр Дотоод хэргийн их сургуультай хамтран төгсөх дамжааны 500 гаруй оюутныг хамруулж, авлигатай тэмцэхэд “ТАНЫ ХЭЛЭХ УРИА” үг зохиох уралдаан</p>	92
<i>Зорилт-5: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр</i>					
5	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог	5.1. Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар /E-Mongolia вэб порталд холбосон,	-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд	“Үндэсний дата төв” УТҮГ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран төрийн үйлчилгээний “E-Mongolia” системд “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн лавлагаа”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай лавлагаа олгох”,	100

	<p>бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.</p>	<p>автоматжуулсан үйлчилгээг оруулна/ мэдээлэл.</p>	<p>суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх.</p>	<p>“Жолооны үнэмлэхийн дэлгэрэнгүй лавлагаа авах”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх тухай тодорхойлолт”, “Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа”, “Жолооны үнэмлэх солих, нөхөн олгох”, “Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах” 7 үйлчилгээ, нэмэлтээр “Жолоодох эрхийн оноо лавлах”, “Авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл лавлах” 2 үйлчилгээ, “Авто тээврийн хэрэгслийн торгууль төлөх”, “Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан талаар цагдаагийн байгууллагын санал”, “Галт зэвсгийн сургалтад суусан тухай лавлагаа”, “Иргэний торгуулийн мэдээлэл лавлах төлөлт хийх” 4 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн “E-Mongolia” системд холбож, иргэд, хуулийн этгээд цахимаар 13 төрлийн лавлагаа, үйлчилгээ авах боломжтой болсон ба шаардлагатай мэдээллийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын мэдээллийн санд цахим хэлбэрт шилжүүлэн байршуулж, лавлагаа авах мэдээллийн өгөгдлийн сангаас хэрхэн авч, гаргах талаар зааварчилгаа, SQL-ийг бэлтгэн Үндэсний дата төвд хүргүүлж, гарч байгаа асуудлыг тухай бүрд хариу өгч, сангийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд дээрх 13 төрлийн лавлагаа, үйлчилгээг нэвтрүүлснээс хойш өнөөдрийг хүртэл 2.256.655 хандалт авсан ба “Жолоодох эрхийн оноо”, Жолоочийн лавлагаа, мэдээлэл”, “Жолооны үнэмлэх солих, нөхөн олгох” лавлагаа, үйлчилгээ хамгийн эрэлт ихтэй байна.</p> <p>Энэ онд “Галт зэвсгийн зөвшөөрөл, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл” зэрэг 3 төрлийн үйлчилгээг “E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд линк байдлаар холболт хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолд заасан бүх үйлчилгээг холбосон бөгөөд тогтоолд заагаагүй 6 төрлийн үйлчилгээг нэмж оруулсан нь тодорхойлолт авах иргэдийн 90 орчим хувь нь цахимаар авч байна. Энэ оны эхний 10 сарын байдлаар нийслэлийн нэгдсэн 6 салбар, 21 аймаг, 330 сумын Засаг даргын тамгын газрын “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр дамжуулан “e-Mongolia” системээр хүн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон хүлээж байсан эсэх тухай тодорхойлолтыг 112.000, жолооны эрхийн лавлагаа, мэдээллийг 411302 иргэн тус тус цахимаар авч, мөн дээрх системээр иргэдээс жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, солиулах, хугацаа сунгуулах 50735, олон улсын жолоодох эрхийн үнэмлэх авах 2531 үйлчилгээг тус тус захиалсныг “Монгол шуудан” ХК-иар хүргүүлжээ. Цахим системд бүрэн холбогдсоноос хойших хугацаанд галт зэвсэг эзэмших, ашиглах зөвшөөрөл хүссэн 730, галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 27 хүсэлтийг хүлээн авч шаардлага хангасан нийт</p>
--	--	---	--	---

				<p>757 иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгож, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа шинээр эрхлэх болон зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 306 байгууллагын хүсэлтийг хүлээн авснаас 11 байгууллагад шинээр, 261 байгууллагын зөвшөөрлийг 1-2 жилийн хугацаатайгаар сунгаж, шаардлага хангаагүй хүсэлт ирүүлсэн 34 байгууллагад татгалзсан тухай шийдвэрийг цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн байна.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх, галт зэвсэг, сум ашиглан спорт сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, галт зэвсэг болон галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн улсын хилээр нэвтрүүлэх, галт зэвсэг худалдан борлуулах төвөөс галт зэвсэг худалдан авах зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд Галт зэвсгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан “Gun.police.gov.mn”, Галт зэвсэг худалдан борлуулах төвийн “GVS.police.gov.mn”, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааны “Sas.police.gov.mn”, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн бүртгэлийн систем “EIS.police.gov.mn”-д хүсэлт илгээсний дагуу шаардлага хангаж байгаа иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгож байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийн гуравдугаар бүлгийн 3.3.4.2, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг 2020-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 3.4.2, мөн сайдын 2021 оны А/150 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 3.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЦЕГ-ын даргын 2021 оны А/245 дугаар тушаалаар Бүртгэл хяналтын төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа “Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан”, “Жолоодох эрх олгох шалгалтад хамрагдах иргэдийн мэдээллийн систем”, “Жолоочийн цахим шалгалт”-ын програм хангамжийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хэсэг байгуулагдсан.</p>	
		<p>5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл</p>		<p>Цахим үйлчилгээний нэгдсэн систем www.emongolia.mn цахим хуудаснаас иргэд өөрийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай цагдаагийн тодорхойлолт /ял шийтгэлийн тодорхойлолт/ авахад уг лавлагааны нэршлийг мэдэхгүй, дамжлага их, ойлгомж муутай байсныг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа “И-Монгол Академи” Улсын төсөвт үйлдвэрийн газартай холбогдож цахим хуудасны хайлт хэсэг дээр “Ял”, “Цагдаагийн тодорхойлолт” гэх зэрэг нийтлэг өгөгдлүүдээр хайлт хийхэд “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт” авах цэс гарч</p>	<p>100</p>

				<p>ирдэг байхаар тохиргоог хийсэн. Энэ онд шинээр “Галт зэвсгийн зөвшөөрөл, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл” зэрэг 3 төрлийн үйлчилгээг “E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд линк байдлаар холболт хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолд заасан бүх үйлчилгээг холбосон бөгөөд тогтоолд заагаагүй 6 төрлийн үйлчилгээг нэмж оруулсан нь тодорхойлолт авах иргэдийн 90 орчим хувь нь цахимаар авч байна.</p>	
		<p>5.3. Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл</p>		<p>Алба хаагчийн гүйцэтгэх ажлыг цахимжуулах, хүний оролцоо, субъектив талыг багасгаж, авлигын үзүүлэлтийг бууруулах зорилго тавьж, 2022 онд “Галт зэвсгийн зөвшөөрөл”, “Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”, “Аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл” зэрэг 3 төрлийн үйлчилгээг “E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд линк байдлаар холболт хийсэн.</p> <p>“E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд цагдаагийн байгууллагын 13 төрлийн зөвшөөрөл, лавлагаа, үйлчилгээг нэвтрүүлснээс хойш өнөөдрийг хүртэл 2.256.655 хандалт авсан ба “Жолоодох эрхийн оноо”, Жолоочийн лавлагаа, мэдээлэл”, “Жолооны үнэмлэх солих, нөхөн олгох” лавлагаа, үйлчилгээ хамгийн эрэлт ихтэй байна.</p> <p>Энэ онд нийслэлийн нэгдсэн 6 салбар, 21 аймаг, 330 сумын Засаг даргын тамгын газрын “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр дамжуулан “e-Mongolia” системээр хүн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон хүлээж байсан эсэх тухай тодорхойлолтыг 112.000, жолооны эрхийн лавлагаа, мэдээллийг 411302 иргэн тус тус цахимаар авч, мөн дээрх системээр иргэдээс жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, солиулах, хугацаа сунгуулах 50735, олон улсын жолоодох эрхийн үнэмлэх авах 2531 үйлчилгээг тус тус захиалсныг “Монгол шуудан” ХК-иар хүргүүлжээ.</p> <p>Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд зааснаар зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан захиргааны хэм хэмжээний актын 2022 оны эхний 10 сарын хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийж, саналын хамт 2022 оны 01/639 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 11.1.6. дахь заалтын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаас</p>	<p>90</p>

				<p>ирүүлсэн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/48 дугаар тушаал “Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс саналыг авч нэгтгэн энэ оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 8д/244 дугаартай албан бичгээр, хэрэгцээ, шаардлагын талаарх танилцуулгыг энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 8д/399 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст тус тус хүргүүлсэн ба дээрх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг төрийн үйлчилгээний “eMongolia” цахим системээр хүлээн авч, хариу өгч байгаа үйл ажиллагаа нь журамд нийцэж байна гэж хариу өгсөн. Энэ оны байдлаар тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацаа сунгуулахаар 816 иргэн, хуулийн этгээд “e-Mongolia” цахим системээр дамжуулан хүсэлт ирүүлсэн ба стандартын шаардлага хангасан телехяналтын камер суурилуулсан 759 иргэн, хуулийн этгээдэд саналыг хүргүүлсэн байна. Албадуудаас байгууллагын цахим хуудас http://mbg.police.gov.mn/ сайтад Тусгай зөвшөөрөл үндсэн цэс, 7 дэд цэсийг шинээр нээж цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомж, журам заавар, шаардлагатай баримт бичгийн жагсаалт, төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг ЦЕГ-ын police.gov.mn сайтын Ял шийтгэлийн тодорхойлолт авах, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн бүрдүүлэх материалын жагсаалт, Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх зөвшөөрөл, Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрөл, ял шийтгэлийн тодорхойлолт авах цэсний мэдээллийг байршуулж иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p>	
		<p>5.4. Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл</p>		<p>Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 1.7-д “Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу 2021 оны “Шударга байдлын үнэлгээ”-гээр Засгийн газрын 32 агентлагаас Цагдаагийн ерөнхий газар 17-д жагссан байна.</p> <p>“Онч шийдэл” Төрийн бус байгууллагын гүйцэтгэсэн авлигын эрсдэлийн болон шударга байдлын үнэлгээний зөвлөмжийн зарим заалт Баянзүрх дүүргийн цагдаагийн газарт хангалтгүй хэрэгжсэн талаар Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээн авч тухайн зөрчлүүд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад нийтлэг тохиолдож байж болзошгүй тул 2022 оны 11 дүгээр сарын</p>	<p>80</p>

				<p>6/9503 дугаартай албан бичгээр холбогдох 61 нэгжид мэдээлэл, чиглэл хүргүүлээ.</p> <p>Цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл, боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын талаарх судалгааг Максима ХХК-аар 2022 онд захиалан хийлгэж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ЦЕГ-ын даргын А/142 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгээс гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын цалинг эхний ээлжинд нэмэгдүүлэх тооцоо судалгааг гаргаж, батлагдсан төсөв, цалингийн сандаа багтаан 1857 алба хаагчийн цалингийн зэрэглэлийг 1 зэрэглэлээр нэмэгдүүлэх шийдвэрийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022.07.01-ний өдрийн А/205 дугаар тушаалаар гаргуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 472 дугаар тогтоолын хавсралтаар “Цагдаа, дотоодын цэргийн төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-г шинэчлэн тогтоосонтой холбогдуулан нийт алба хаагчдын цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлүүлээд байна.</p> <p>Зөвлөмжийн “Цагдаагийн байгууллагын бүтцийн зөв, оновчтой дотоод зохион байгуулалт /нэгдэх, нийлүүлэх, хуваах гэх мэт/-ыг хийж, чиг үүрэг давхардсан, ачаалал бага орон тоог ачаалал ихтэй гүйцэтгэх анхан шатны нэгжид шилжүүлэх замаар ажлын ачааллыг бууруулж, гүйцэтгэлийг сайжруулах” заалтын хүрээнд : Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, давхардлыг арилгах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын эрх хэмжээний хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах тухай 24 асуудлыг шийдвэрлэсэн. Тухайлбал: /Тээврийн цагдаагийн албаны Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Хүний нөөцийн хэлтсийг татан буулгаж, мөн албаны Захиргааны удирдлагын газарт нэгтгэсэн. ЦЕГ-ын Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс, Төрийн нууцын хэлтсийг нэгтгэж Дотоод хяналт-аюулгүй байдлын газар байгуулсан гэх мэт/.</p>
<i>Зорилт-6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр</i>				
<i>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4</i>				
6	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон	6.1. Тухайн жилийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.	- Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашиг	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 11, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээлэл давхардсан тоогоор 156, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

нийтэд тухай бүр нь мэдээлэх.		сайжирсан байх.	зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 17 мэдээллийг тус тус шилэн дансны цахим систем www.shilendans.gov.mn -нд хуулийн хугацаанд нь байршуулж, тендерийн урилга, үр дүнг өдөр тутмын сонин буюу “Өглөөний сонин”, www.tender.gov.mn сайтад тухай бүр нь байршуулан олон нийтэд ил тод мэдээлсэн.	100
	6.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.	-Мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр тусгагдаж, цахим хуудсанд байршуулсан байх.	Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулж, Үндэсний аудитын газрын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/712 дугаар албан бичгээр “Зөрчилгүй санал дүгнэлт” ирүүлсэн. Санхүү, аж ахуйн албаны жилийн эцсийн санхүүгийн тайланг https://shilendans.gov.mn/ цахим хуудсанд 2022 оны 04 дүгээр сарын 06, Гэрээт нэгжийн жилийн эцсийн санхүүгийн тайланг https://shilendans.gov.mn/ цахим хуудсанд 2022 оны 04 дүгээр сарын 07-нд тус тус байршуулсан. /Жилийн эцсийн байдлаар тайлагнах хугацаа болоогүй./	100
	6.3. Дараа жилийн төсвийн төсөөлөл /8 дугаар сарын 15-ны дотор/ цахим хуудсанд байршуулах.		Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ЦЕГ-ын www.police.gov.mn цахим хуудасны шилэн дансны төсөв гүйцэтгэл хэсэгт байршуулсан.	100
	6.4. (9.1.4.2) Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.		Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулж Үндэсний аудитын газрын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/712 дугаар албан бичгээр “Зөрчилгүй санал дүгнэлт” ирүүлсэн. Санхүү, аж ахуйн албаны жилийн эцсийн санхүүгийн тайланг Цагдаагийн ерөнхий газрын https://police.gov.mn/home цахим сайтын Шилэн данс цэсийн шинэ дансны нэгдсэн системийн https://shilendans.gov.mn/ цахим хуудсанд 2022 оны 04 дүгээр сарын 06, Гэрээт нэгжийн жилийн эцсийн санхүүгийн тайланг https://shilendans.gov.mn/ цахим хуудсанд 2022 оны 04 дүгээр сарын 07-нд тус тус байршуулсан.	100
	6.5. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим		-Аудитын дүгнэлтийн хэрэгжилт	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 01-11 дүгээр сарын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 3 дэд цэсээр мэдээ байршуулсан байдалд сар бүр хяналт

		хуудсанд байршуулж, аудитын байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах, нэгжүүдийг мэдээллээр бүрэн хангах.	сайжирч, зөрчлийг арилгасан байх.	тавин, аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийн биелэлтийг нэгтгэж, ЦЕГ-ын даргын баталсан “Санхүүгийн үйл ажиллагаа, алба хаагчийн ажлыг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу санхүүгийн үйл ажиллагааны энэ оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын үнэлгээнд тус тус оруулж дүгнэлээ. 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, цаашид анхаарах асуудлаар 7 чиглэлээр 28 зүйлийн зөвлөмж боловсруулан энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 6/585 дугаар албан бичгээр харьяа 54 байгууллагад хүргүүлсэн. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын шалгалтын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн эхний хагас жилийн биелэлтийг байгууллага тус бүрээр нэгтгэн гаргаж, холбогдох материалын хамт Үндэсний аудитын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Дотоод хяналт, аюулгүй байдлын газарт албаны даргын энэ оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 14/1054, 14/1055, 14/1062 дугаар албан бичгээр болон цахимаар, жилийн биелэлтийг гаргаж албаны даргын даргын энэ оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 14/1390 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 14/1389 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт тус тус холбогдох нотломж, материалын хамт цаасаар болон цахимаар хүргүүлсэн. Биелэлт тус бүр 100 хувь хангагдсан байна.	
<i>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалт</i>					
7	Шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл өгөх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	7.1. Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх, /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/ цахим хуудсанд байршуулах.	-Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх.	Монгол Улсын Их Хурлаас баталсан төсвийг 01 дүгээр сарын 08-ны дотор Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын дагуу 9 удаа өөрчлөлт орсон төсвийг сар бүрийн 08-ны дотор police.gov.mn сайтад байршуулан нийтэд мэдээлсэн. 2022 оны 1-11 дүгээр сарын төсөв, гүйцэтгэлийг гарган Шилэн дансны нэгдсэн системд тухай бүр байршуулах 5, сар бүр байршуулах 5, нийт 10 мэдээллийг тус тус хуулийн хугацаанд, үнэн зөв байршуулж ажилласан.	100
		7.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/		Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд /ЦЕГ-ын гэрээт алба, Хууль зүй, дотоод хэргийн яам/ “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэг, “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл” хэсэгт татварын бус орлогын нийт 8 удаагийн 1426,7 сая төгрөгийн ажил гүйлгээний баримт, татварын орлогын 215,7 сая төгрөгийн ажил гүйлгээний баримтыг тухай бүр өссөн дүнгээр байршуулсан.	100

		7.3. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан.		Тайлант хугацаанд хандив, тусламжаар авсан хөрөнгө, бараа материал байхгүй.	100
		7.4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт мэдээлэх.		Санхүү, аж ахуйн алба нь Шилэн дансны нэгдсэн системд 01 дүгээр сард 8, 02 дугаар сард 28, 03 дугаар сард 47, 04 дүгээр сард 56, 05 дугаар сард 50, 06 дугаар сард 65, 07 дугаар сард 46, 08 дугаар сард 54, 09 дүгээр сард 45, 10 дугаар сард 52 нийт 451 удаагийн 127,4 тэрбум төгрөгийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлагын гүйлгээний мэдээллийг холбогдох шийдвэрийг PDF файлаар хавсаргаж байршуулсан. Гэрээт алба нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 удаагийн 230.4 сая төгрөг, зарлагын 5 удаагийн 187,9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээний баримтыг байршуулсан.	100
		7.5. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлэх.		Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн тушаал 246, гэрээ 145 нийт 391 мэдээллийг тухай бүр байршуулсан.	100
		7.6. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах.		Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан хамтран хэрэгжүүлж буй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд 2020-2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 446,7 сая төгрөгийн санхүүжилт авч нэмэлт санхүүжилтийн төрийн сангийн 100900012412 тоот данснаас зарцуулах эрхийг нээлгэн гүйцэтгэлээр 241,2 сая төгрөгийн зардал гарч үлдэгдэл санхүүжилт нь 11/25-12/10 хүртэлх “Нандин бүхнээ хамгаалъя” 16 хоногийн аяны хэмжээнд гарахаар хүлээгдэж байна. Уг хөтөлбөрийн 5 саяас дээш үнийн дүнтэй орлого зарлагын гүйлгээг шилэн дансны нэгдсэн системд тухай бүр байршуулсан.	100
<i>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт</i>					
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах	8.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах.	- Цахим хуудсанд байршуулсан байх.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/250, 2022 оны А/52, А/118, А/235 дугаар тушаалаар тус тус “Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-нд өөрчлөлт оруулж баталсан. Тус төлөвлөгөөний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 10.3 тэрбум, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 23.3 тэрбум төгрөг тусгагдсан	100

ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах.			бөгөөд www.tender.gov.mn , www.shilendans.gov.mn -нд цахим системд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.	
	8.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/		Цагдаа, дотоодын цэргийн хэмжээнд хөрөнгө оруулалтад 10.3 тэрбум, урсгал төсөвт 23.3 тэрбум нийт 33.3 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан. Үүнээс цахимаар 30.7 тэрбум буюу 91.5 хувь, Төрийн болон албаны нууцын тухай хуулиар 2.9 тэрбум буюу 8.5 хувь нь нууцад хамааран худалдан авалт хийгдэж тусгагдсан бөгөөд тухайн төлөвлөгөөний хүрээнд давхардсан тоогоор нийт 60 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -нд болон өдөр тутмын сонин буюу “Өглөөний сонин” хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, мөн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаарх мэдээллийг www.shilendans.gov.mn цахим системд тухай бүрд оруулан олон нийтэд ил тод мэдээлсэн.	100
	8.3. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан.		Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоол, Төрийн худалдан авах ажиллагааны газрын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хөрөнгө оруулалтын 10.3 тэрбум, урсгал төсвийн 23.3 тэрбум нийт 33.3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчид хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100
	8.4. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн. /Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан./		Энэ онд Худалдан авах ажиллагаанд бие даасан аудитын хяналт, шалгалт явагдаагүй болно.	100
	8 5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	- Цахим хуудсанд байршуулсан байх.	УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягтыг 2022 онд албаны шалгалт явуулсан болон худалдан авах	85

		<p>урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах”, 9 дүгээр зүйлд заасан “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх тухай” заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж ажиллах.</p>		<p>ажиллагаанд оролцсон нийт алба хаагчдаас гаргуулан авч, санд бүртгэх, цаашид үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллахыг Эрх бүхий албан тушаалтнуудад мэдээлэл хүргүүлсний дүнд Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим санд 2021 онд 151 бүртгэгдэж байсан мэдэгдлийн тоо энэ оны жилийн эцсийн байдлаар 370 болж өссөн.</p> <p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 139.61В маягтын дагуу цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдсон тохиолдол бий эсэхийг тодруулах зорилгоор Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар-20, Хан-уул дүүрэг дэх цагдаагийн газар-19, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар-18, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар-7 тус тус хороо хариуцсан хэсгийн байцаагч нараас түүврийн аргаар судалгаа авч ажиллаа. Судалгаанд нийт 66 хэсгийн байцаагч оролцсон бөгөөд цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд гомдол мэдээлэл хянан шалгаж шийдвэрлэх явцад болон өөр бусад тохиолдлоор хөндлөнгөөс нөлөөлөх, мөнгө, эд зүйл, өгөхийг оролдсон тохиолдол гараагүй байна.</p>	
	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах.</p>	<p>8.6. Цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.</p>	<p>- Зөвшөөрөл олгож буй бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтийг танилцах боломжоор хангасан байх.</p>	<p>Бүртгэл хяналтын төвийн албан ёсны License.police.police.gov.mn цахим хуудсанд жолоочийн бүртгэлийн хуудас болон үнэлгээний хуудас, тээврийн хэрэгслийн ангилал нэмүүлэх сургалтын үнэлгээний хуудас, эрүүл мэндийн маягыг тус тус татаж авах, жолоочийн үнэмлэх үрэгдүүлсэн, нөхөн авах, Монгол улсын болон Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх шинээр авах, гадаад улсын жолоочийн үнэмлэх солих, тээврийн хэрэгсэл жолоодох эрх, зөрчлийн оноо сэргээх, жолоочийн үнэмлэхний лавлагаа авах, төрийн бус байгууллагын сургалтын хуваарь, хаяг байршил, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан авах, улсын хилээр нэвтрүүлэх, шинээр гэрчилгээ авах, гэрчилгээ сунгуулах, гэрчилгээ гээгдүүлсэн иргэний бүрдүүлэх материал, Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”, Хууль зүйн сайдын 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”, “Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг”, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/292 дугаар тушаал “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”, Хувийн хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Хувийн хамгаалалт эрхлэх гэрчилгээ олгох, хяналт тавих” зэрэг хууль тогтоомжуудыг шинэчлэн байршуулсан.</p>	<p>100</p>

		<p>8.7. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа.</p>		<p>Бүртгэл хяналтын төвөөс цахим системд бүрэн холбогдсоноос хойших хугацаанд галт зэвсэг эзэмших, ашиглах зөвшөөрөл хүссэн 730, галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 27 хүсэлтийг хүлээн авч шаардлага хангасан нийт 757 иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгож, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа шинээр эрхлэх болон зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 306 байгууллагын хүсэлтийг хүлээн авснаас 11 байгууллагад шинээр, 261 байгууллагын зөвшөөрлийг 1-2 жилийн хугацаатайгаар сунгаж, шаардлага хангаагүй хүсэлт ирүүлсэн 34 байгууллагад татгалзсан тухай шийдвэрийг цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн байна. Мөн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих хуулийн дагуу 55 аж, ахуйн нэгж байгууллагын 558 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгож, 1094 тээвэрлэлтийн маршрут, замналын хүсэлтийг хүлээн авч баталгаажуулсан.</p>	98
		<p>8.8. Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаар мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байдал.</p>		<p>“Е-Монголиа” платформ дээр суурилсан “Үндэсний цахим шуудан”-гийн системийг нэвтрүүлсэн тул иргэдэд шаардлагатай мэдээлэл, мэдэгдэл хүргүүлэх, өргөдөл, гомдлыг хүлээн авч хариу хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын гишүүд, хууль хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллагын “Үндэсний цахим шуудан”-нд цагдаа, дотоодын цэргийн нийт 63 анги, байгууллагын цахим шуудангийн хаягийг бүртгүүлж, цахим шуудан бүртгүүлсэн байгууллагуудад МДШШУА-ны 2022 оны 13/1827 дугаар албан бичгээр иргэн, хуулийн этгээдээс “Үндэсний цахим шуудан”-гийн хаягаар дамжуулж мэдээлэл, мэдэгдлийг хүлээн авах, гомдол мэдээлэл гаргах, санал хүсэлт зэргийг хүлээн авч хариу өгч ажиллах талаар ажлын чиглэл хүргүүлж ажилласан.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрөл болон замнал, маршрут батлах, гэрээт болон, хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, галт зэвсгийн шилжилт хөдөлгөөн, гэрчилгээ олгох үйлчилгээ, олгогдож буй зөвшөөрлийн чиглэл ажил хариуцсан алба хаагчдын албаны мэдээлэл, холбоо барих утасны дугаарын хамт License.police.police.gov.mn цахим хуудсанд байршуулсан.</p>	100
		<p>8.9. Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл</p>		<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, Хууль</p>	

		ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэх.		<p>зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”, тээврийн хэрэгслийн жолоодох эрх сэргээх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, Төрийн бус байгууллагуудтай 2022 онд байгуулсан сургалтын гэрээний авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтуудын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зурагт хуудас, брошур, ном, сэтгүүл, зөвлөмжийг сургалтын анги, танхимд байрлуулж, иргэд, олон нийтэд сурталчилсан. - Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны ахлах комиссар С.Галбадрах энэ оны 06 дугаар сарын 06-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Жолоочийн эрх, зөрчлийн оноо сэргээх үйл ажиллагаа эрхэлж байгаа 13 төрийн бус байгууллагын удирдлага, сургагч багш нарын 28 хүнийг хамруулан зохион байгуулсан. <p>Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын сэдэв, агуулгаас гадна авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан агуулгын хүрээнд анхааруулга, сэрэмжлүүлгийг сургалтын тодорхой цагт багтаан иргэд, сурталцагчдад сурталчлан хүргэсэн.</p>	
<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>8.10. Цагдаагийн алба хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг 24 цагийн хугацаанд тасралтгүй шуурхай хүлээн авах суурин телефон /126/ утсыг Цагдаагийн төв байгууллагын жижүүрт байрлуулж мэдээллийг харьяалах алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлэн хянан шалгах, хариуцлага хүлээлгэх,</p>	<p>- Цахим хэлбэрээр гомдол хүлээх авах эрх зүйн орчин бүрдсэн байх.</p>		<p>Цагдаагийн байгууллагаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаарх мэдээллийг иргэдээс 24 цагаар хүлээн авах 126 тусгай дугаарын утсаар 2022 онд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой 652 гомдол мэдээлэл ирүүлснээс 607 гомдол мэдээллийг харьяа газар хэлтсүүд шалгаж шийдвэрлэн, буруутай нь тогтоогдсон 26 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулан, 45 гомдол, мэдээллийг ажиллагаанд шалгаж байна.</p> <p>“Е-Монголиа” платформ дээр суурилсан “Үндэсний цахим шуудан”-гийн системийг нэвтрүүлсэн тул иргэдэд шаардлагатай мэдээлэл, мэдэгдэл хүргүүлэх, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын гишүүд, хууль хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан шийдвэрийн дагуу “Үндэсний цахим шуудан”-нд цагдаа, дотоодын цэргийн нийт 63</p>	<p>100</p>

		дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.		анги, байгууллагын цахим шуудангийн хаягийг бүртгүүлж, цахим шуудан бүртгүүлсэн байгууллагуудад МДШШУА-ны 2022 оны 13/1827 дугаар албан бичгээр иргэн, хуулийн этгээдээс “Үндэсний цахим шуудан”-гийн хаягаар дамжуулж мэдээлэл, мэдэгдлийг хүлээн авах, гомдол мэдээлэл гаргах, санал хүсэлт зэргийг хүлээн авч хариу өгч ажиллах талаар ажлын чиглэл хүргүүлж, эрх зүйн орчинг бүрдүүлсэн.	
		8.11. Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/	- Цахим хуудсанд байршуулсан байх.	<p>ЦЕГ-ын албан ёсны www.police.gov.mn цахим сайт, ЦЕГ-ын Хэвлэл, мэдээллийн төвийн олон нийтийн цахим сүлжээний Фэйсбүүк цахим хуудаст болон алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдийн цахим сайт, цахим хуудаст цагдаагийн байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг байршуулж иргэд олон нийтэд тухай бүр мэдээлж, сурталчлан ажилласан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага 35 цахим сайт, 57 нүүр хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг нэг цонхоор дамжуулж байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн талаар 534, урьдчилан сэргийлэх чиглэлээр 3384, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавьяаг алдаршуулах чиглэлээр 1348, бусад 653 мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээсэн байна.</p> <p>Хэвлэл мэдээллийн төвийн фэйсбүүк пэйж хуудаст цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын онцлог үйл явдал, аян арга хэмжээ, ярилцлага, 805 мэдээ мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд түгээж ажилласан. Мэдээ, мэдээлэл, ярилцлага, постерыг давхардсан тоогоор 6.192.939 хүн үзэж, 220.0054 хүнд таалагдаж, 16.855 удаа хуваалцаж, 4949 удаа сэтгэгдэл үлдээсэн байна. Твиттер хуудаст 36 мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.</p>	85
		8.12. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар.		<p>“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын тус хэлтэст хамааралтай заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын тогтоол /40/, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан тушаал /75/, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан тушаал /56/, Улсын Ерөнхий прокурорын тушаал /19/-ын жагсаалтыг гаргаж, холбогдох эрх зүйн актууд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын кодод баяжилт хийж, тухай бүр цагдаагийн байгууллагын www.police.gov.mn, www.system.police.gov цахим хуудсанд тус тус байршуулсан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хууль тогтоомжоор боловсруулсан 5 гарын авлага, мэдээлэл, эрх зүйн актаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын тогтоол 2, Монгол</p>	90

				<p>Улсын Дээд шүүхийн тогтоол 1, Сайдын тушаал 5, ЦЕГ-ын даргын 15 тушаалын мэдээллийг тухай бүрт нэгжүүдэд хүргүүлсэн.</p>	
		<p>8.13. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах.</p>		<p>“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2007 оны 58/62 дугаартай тушаалаар хамтран баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ыг цагдаагийн байгууллагын www.police.gov.mn цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2007 оны 58/62 дугаартай тушаалаар хамтран баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ыг цагдаагийн байгууллагын www.police.gov.mn, цахим хуудсанд байршуулсан.</p>	100
		<p>8.14. Төсвийн орлого бүрдүүлэлт, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг цахим хуудсанд байршуулах.</p>		<p>Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй.</p>	100

	<p>Иргэдийн гаргасан өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх, мэдээлэл өгөх, ил тод, нээлттэй суваг ажиллуулах.</p>	<p>8.15. Цагдаагийн байгууллагын албан ёсны /service.police.gov.mn/ цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах. - Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах.</p>	<p>- Иргэн, хуулийн этгээд өөрийн гаргасан өргөдөл, гомдлын явц байдал шийдвэрлэлтийг цахимаар хянах боломж бүрдсэн байх.</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын өргөдөл, гомдол хүлээж авах police.gov.mn хаягаар 2022 онд иргэд, байгууллагаас нийт 293 өргөдөл, гомдол ирснээс 58 өргөдлийг хүлээн авч бүртгэн, удирдлагад танилцуулж, цохолтын дагуу харьяа алба нэгжид шалгуулахаар шилжүүлж, хуулийн хугацаанд хариу өгч, шийдвэрлэсэн.</p> <p>Давхардсан тоогоор 369 иргэнд харьяалах цагдаагийн газар, хэлтэст өргөдөл, гомдлоо гаргах талаар хариу хүргүүлж ажилласан болно.</p> <p>Цагдаагийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан complaints@police.gov.mn хаягаар иргэдээс өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, цахим бүртгэл хөтлөн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Цахим хуудсанд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх хууль”-ийн зүйл заалтын мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний нэр цол, харилцах утасны дугаар, өргөдөл гомдол хүлээн авах цагийн хуваарь, Цагдаагийн ерөнхий газрын удирдлага иргэдийг хүлээж авч, уулзах хуваарийг байршуулсан.</p>	<p>98</p>
		<p>8.16. Иргэд, байгууллагаас гаргасан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр хянах, ямар шатанд байгааг мэдээлэх нээлттэй суваг ажиллуулах.</p>		<p>Орчин үеийн технологийг ашиглах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, шударга, ил тод хүргэх чиглэлээр иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлт бүрийг хүлээн авах цагдаагийн байгууллагын www.police.gov.mn цахим хуудсанд “Өргөдөл, гомдол хүлээж авах” цэсийг байршуулж, complaints@police.gov.mn хаягаар хүлээн авах ажлыг ЦЕГ-ын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс хариуцаж, цахим сангийн хэвийн үйл ажиллагааг албаны харьяа Мэдээллийн технологи, холбооны төв хариуцан ажиллаж байна.</p> <p>ЦЕГ-ын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 1111 төвд ирүүлсэн гомдол, мэдээллийг нэгтгэн хүлээн авч, шийдвэрлэлтийг хариу тайлагнаж байх холболт, тохируулгыг хийж, өргөдөл, гомдол хариуцсан алба хаагчийн мэдээллийг хүргүүлж, 1111 нэгдсэн төвтэй хамтран ажилласан.</p> <p>Цагдаагийн байгууллага, алба хаагчид иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаараас кирил үсгээр богино зурвас буюу /SMS/ хэлбэрээр өргөдөл, гомдлыг хэн, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг гомдол, мэдээлэл гаргагчийн гар утсанд автоматаар очих боломжийг бүрдүүлэхээр техникийн боломжийг бүрдүүлж, “өргөдөл, гомдол”, “зөрчил”, “гэмт хэрэг”-ийн програм хангамжуудад өөрчлөлт оруулж, “Скайтел”, “Мобиком”,</p>	<p>100</p>

				<p>“Юнител”, “Жи-Мобайл” оператор байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>Дээрх үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг хийхээр цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж 106 иргэнээс 6 асуултаар /утсаар/ санал, асуулга авч авахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сэтгэл ханамжтай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.</p> <p>Гомдол, мэдээлэл гаргасан иргэнд цагдаагийн байгууллагаас ямар арга хэмжээ авч ажилласан талаарх мэдээллийг SMS хэлбэрээр хүргэх програм хангамжийг нэвтрүүлснээр энэ оны эхний 11 сарын байдлаар нийт 1.383.638 мэдээллийг иргэдийн гар утсанд хүргүүлсэн.</p>	
<p>Алба хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.</p>		<p>8.17. Цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах, боловсронгуй болгох.</p>	<p>- Ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр боловсруулж баталсан байх.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Зохион байгуулалтын бүтэц батлах, хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай” тушаалаар Гадаад харилцаа, энхийг ажиллагаа хариуцсан нэгж, Дотоод хяналт-аюулгүй байдлын газар, Зөрчлийн хэрэг бүртгэх газар, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн зохион байгуулалтын чиг үүрэг, цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг баталсан.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/317 дугаар тушаалаар “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс”-ийн нэршлийг “Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтэс” болгон өөрчилж, орон тоог шинээр нэмэгдүүлсэн.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/51 дүгээр тушаалаар Зөрчлийн хэрэг бүртгэх газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг шинээр байгуулж, орон тоо нэмэгдүүлж, шилжүүлсэн.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/141 дүгээр тушаалаар цагдаагийн байгууллагын бүтцэд “Дотоод хяналт-аюулгүй байдлын газар”-ыг байгуулж, мөн газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Төрийн нууцын хэлтсийн чиг үүрэг, эрх хэмжээг батлагдсан орон тооны хамт шилжүүлж, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, Хүний нөөцийн хэлтсээс шинээр бий болсон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулсан.</p> <p>Дээрх зохион байгуулалтын бүтэцтэй холбогдуулан Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас ирүүлсэн саналын дагуу Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 100, 112, 113, 114, 117, 122, 137, 139, 140, 141, 700, 718, 805, 807, 809, 816, 817, 914, 916, 917, 924, 934, 938, 949-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, батлуулахад бэлэн болгосон.</p>	<p>100</p>

				<p>Зөрчлийн хэрэг бүртгэх газраас ирүүлсэн саналын дагуу “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах оруулах саналыг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар батлуулж, 2022 оны 5г/4061 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас хэлтэс, албан тушаалын нэршлийг өөрчлөх талаар ирүүлсэн албан бичгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, дараах анги, байгууллагад зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:</p> <p>1.“Экологийн цагдаагийн албаны шинжээчийн албан тушаалын нэршлийг мөрдөгч-шинжээч болгох эрх зүйн үндэслэлийн талаар судалж, бүтэц, орон тооны асуудлыг цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, хуульд заасан чиг үүргийн хүрээнд ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах замаар орон тоо, албан тушаалын нэршлийг өөрчлөх боломжтой талаар хариуг 2022 оны 5г/2603 дугаартай албан бичгээр Экологийн цагдаагийн албанд хүргүүлсэн.</p> <p>2.Эрүүгийн цагдаагийн албаны “Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”-ийн нэршлийг “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс” болгон өөрчлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, өөрчлөх боломжтой талаар хариуг 2022 оны 5г/2702 дугаартай албан бичгээр Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>3.“Улаанбаатар цагдаагийн хүрээ”-ний нэршлийг өөрчилж, “Улаанбаатар цагдаа, дотоодын цэргийн хүрээ” болгох тухай ирүүлсэн албан бичгийг холбогдох эрх зүйн актын хүрээнд судалж, “Улаанбаатар цагдаа, дотоодын цэргийн хүрээ” болгох нь байгууллагын чиг үүрэг өөр, цэргийн хүрээний талаар эрх бүхий албан тушаалтнаас батлан мөрдүүлж байгаа нарийвчилсан зохицуулалт хүчин төгөлдөр байгаа тул давхардуулан зохицуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага тодорхойгүй байх тул саналыг дэмжихгүй талаар 2022 оны 5г/3917 дугаартай албан бичгээр зөвлөмжийг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>4.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас албаны “Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс”-ийн нэршлийг “Кибер аюулгүй байдлын хэлтэс” болгон өөрчлөх тухай ирүүлсэн албан бичгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, Кибер аюулгүй байдлын Олон улсын стандарт нэршил, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн тус албаны Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс”-ийн нэршлийг “Кибер аюулгүй байдлын хэлтэс” болгон өөрчлөхөд</p>
--	--	--	--	--

				цагдаагийн байгууллагын бусад нэгжийн нэршил, чиг үүрэгтэй давхардал үүсэхгүй талаар зөвлөмжийг 2022 оны 5г/4362 дугаартай албан бичгээр Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.	
	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.	8.18. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажлын байрны сонгон шалгаруулалтын мэдээллийг тухай бүр шинэчилж, иргэдийн танилцах боломжийг бүрдүүлэх. /тухай бүр шинэчилсэн/	- Цагдаагийн албаны хүний нөөцийн ил тод байдал сайжирна.	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор 2022 онд Ахлагчийн сургуулийн элсэлтийн шалгалтыг 5 удаа зохион байгуулахаар төлөвлөж, 5 удаагийн элсэлтийн шалгалтыг зохион байгуулаад байна.</p> <p>Элсэлтийн шалгалт зохион байгуулахтай холбоотойгоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт болон сул орон тооны мэдээллийг Цагдаагийн ерөнхий газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын www.police.gov.mn цахим хуудсанд байршуулж, “Өдрийн сонин”, “Өнөөдөр сонин”-д нийтлүүлэн, иргэдэд 70191043, 70191095 дугаарын утсаар иргэдийг мэдээллээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулсан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2022 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх санал ирүүлсэн 1258 алба хаагчийн материалыг нэгтгэж, шалгуур, шаардлага хангасан эсэхэд тулгалт хийж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн б/02 дугаар тогтоолоор ахлагчаас офицер албан тушаалд 332, ахлах албан тушаалд 481, чиглэлийн ахлах, тасаг, хэсгийн даргын албан тушаалд 226, алба, газар, хэлтсийн даргын албан тушаалд 99, нийт 1270 алба хаагчийг албан тушаал шатлан дэвшүүлэх нөөцийн жагсаалтад оруулан сургалтад хамруулахаар бүртгэж, цагдаагийн байгууллагын цахим сангийн “гарын авлага” цэсэнд байршуулсан.</p> <p>Дээрх зарыг neguun.mn, arslan.mn, updown зэрэг цахим сайт, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан ёсны фэйсбүүк, цахим хуудаст 120 удаа нийтэлснийг 2,267,142 хүн үзэж, 6512 хүнд таалагдаж, 546 хүн сэтгэгдэл үлдээж, 4512 хүн удаа бусадтай хуваалцсан байна.</p>	100
		8.19. Хүний нөөцийн томилгооны ил тод байдал, шагнал урамшууллын шударга байдлыг нэмэгдүүлэх, нөлөөллийг багасгах алба хаагчдыг мэдээллээр хангах зорилгоор алба хаагчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар хэрхэн		Цагдаагийн ерөнхий газрын даргын 1999 тушаалаар 10183, Дотоодын цэргийн командлагчийн 99 тушаалаар 431, Тэргүүн дэд, дэд, Захиргааны удирдлагын газрын даргын 116 тушаалаар давхардсан тоогоор 1070 нийт давхардсан тоогоор 11800 алба хаагчийн асуудлыг шийдвэрлүүлж, мэдэгдэх хуудсыг тухай бүр нэгжүүдэд хүргүүлэн алба хаагчдад танилцуулж, гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт баяжилтаар хийсэн байна.	80

		<p>шийдвэрлэсэн талаар шийдвэр гарсан даруйд мэдээлж байх</p>		<p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Тэргүүний болон шилдэг алба хаагч, байгууллага шалгаруулах /код-133/ журам”-ыг өөрчлөн найруулж, шинэчлэн батлуулсан</p> <p>Хүний нөөцийн томилолт, шагнал урамшуулалтай холбоотойгоор гаргасан өргөдөл, хүсэлт, албан бичиг, холбогдох материалыг судалж, хууль, журамд заасан шаардлага, шалгуур хангахгүй алба хаагчдын материалыг шийдвэрлэх боломжгүй талаар албан бичгээр хариуг өгсөн.</p> <p>Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвтэй хамтран “Хүний нөөцийн цахим сан”-г шинэчлэх талаар 2 удаагийн уулзалт зохион байгуулж, 56/2482, 56/3755 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.</p>	
<p><i>Нийт 47 ажил, арга хэмжээ 94.1 хувийн хэрэгжсэн.</i></p>					

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР